



**"ГЕРМЕС ЦЕНТР" ХУВЬЦЛАТ КОМПАНИЙН
ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үүднээс компанийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог бий болгох, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд байнгын тогтмол хяналтыг тавьж, дараалсан хяналт шалгалтыг хийх, дотоод аудитын үйл ажиллагааг тогтмол эерэгжүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Дотоод Хяналтын Тогтолцоо

- 2.1. Компанийн Дотоод Хяналтын Тогтолцоо нь дараах хэлбэртэй байна. Үүнд:
- Хянан Шалгах Зөвлөл
 - ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороо
 - Дотоод Хяналтын Алба
 - Хөндлөнгийн Аудитын Хяналт
- 2.2. Хянан Шалгах Зөвлөл нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдох бөгөөд энэхүү ХШЗ-ийн ажиллах эрх, үүргийг компанийн дүрэмд тодорхой заасан байна.
- 2.3. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороог компанийн ТУЗ-өөс томилон ажиллуулна. Аудитын Хороо нь гурван хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-ийн тогтоолоор хорооны бүрэлдэхүүнийг томилон ажиллуулна.
- 2.4. Дотоод Хяналтын Албыг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилж, эрх үүргийг нь энэхүү журамд тодорхой чиглүүлж өгнө. ДХАлба нь хоёр хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 2.5. Хөндлөнгийн Аудитын Хяналтыг Аудитын Хороотой зөвшилцөөний үндсэн дээр компаниас хараат бус мэргэжлийн өндөр ур чадвартай, бусдын боловцд үл автаж, холбогдох хууль ёсны зөвшөөрөлтэй хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон шалгаруулж ажиллуулна.

Гурав. Аудитын Хорооны ажиллах эрх, үүрэг

- 3.1. Аудитын Хороо нь компанийн үйл ажиллагаа батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх, тэдгээрийн биелэлт ямар байгаа эсэх, компанийн санхүүгийн удирдлага зохиистой байгаа эсэх, санхүү, нягтлан бодох бүртгэл нь үнэн зөв хөтөлгөж байгаа эсэх, компанийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа зохиистой байгаа эсэх, компанийн дотоод заавар, журмын хэрэгжилтийг хэрхэн мөрдүүлэн ажиллаж байгаа эсэх, нийтэд хүргэх мэдээ, мэдээллийг цаг тухайд нь хүргэж байгаа эсэх, ДХА-ны үйл ажиллагаа зохиистой байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллана.
- 3.2. Аудитын Хороо нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдаж, компанийн үйл ажиллагаанд хийсэн хяналтын ажлын үр дүнг хэлэлцэж, шийдвэр гаргаж байна.
- 3.3. Аудитын Хороо нь шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, түүгээр хэлэлцэх асуудлыг санал болгох, ДХАлбаны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлэх эрхтэй байна.

- 3.4. Аудитын Хороо нь хөндлөнгийн аудитын үйл ажиллагаа зохих журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахаас гадна хөндлөнгийн аудиторроор ажиллаж компанийг сонгон шалгаруулахад оролцож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлд санал гаргах эрхтэй байна.

Дөрөв. Дотоод Хяналтын Албаны ажиллах эрх, үүрэг

- 4.1. Дотоод Хяналтын Алба нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу компанийн удирдлагаас баталсан бодлого нийгдвэрийн хэрэгжилт, тухайн жилийн төсөв төлөвлөгөөний биедэлт, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа заавар, журмын хэрэгжилт, компанийн үйл ажиллагаанд оршиж буй эрсдлийг тухай бүр нь илрүүлэн үнэлэх, түүнийг бууруулах, цаашид учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, санхүү нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан мэдээ цаг хугацаандаа үнэн зөв гарч байгаа эсэхэд хяналт тавьж, компанийн эд хөрөнгө, материалын хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих, компанийн ажилтан бүрийн ажил үүргийн биелэлтийг хянах, компанийн үр ашгийг дээшлүүлэх чиг үүрэгтэйгээр компанийн Гүйцэтгэх Захирал болон Аудитын Хороонд ажлаа тайлагнах зарчмаар ажиллана.
- 4.2. ДХАлба нь компанийн эрх бүхий албан тушаалтнуудаас хараат бусаар үүрэгт ажлаа гүйцэтгэн явуулна.
- 4.3. Компанийн төсөв, төлөвлөгөөнд тусгагдаагүй их хэмжээний хэлцэл, эсхүл сонирхлын зөрчил бүхий хэлцэл хийгдэж байгаа эсэхэд хяналт тавина.
- 4.4. ДХАлба нь шалгалтын үр дүнгээ ХШЗ болон АХороонд хүргүүлж байхаас гадна шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хуралд ажлаа тайлагнаж байна.

Тав. Бусад

- 5.1. Хянан Шалгах Зөвлөл, Аудитын Хороо, Дотоод Хяналтын Алба нь хөндлөнгийн аудитор, хөндлөнгийн шинжээчдээ шаардлагатай мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө авах эрхтэй байна.
- 5.2. Хянан Шалгах Зөвлөл, Аудитын Хороо, Дотоод Хяналтын Албаны гишүүдийн тухай төвч танилцуулга, намтар болон үйл ажиллагааны тайланг тухайн жилд багтаан гаргаж, дараа жилийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.